

АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 03 ДУГААР САРЫН 01 ДАХЬ ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭ

2018-03-02

№	Хяналтын чиглэл	Хийгдсэн ажил	Ирэх 7 хоногийн төлөвлөгөөт ажил
1	ТЗЭУХ	<ul style="list-style-type: none"> • Даргын зөвлөлийн 3 дугаар хурал болж, Цагаан сарын баярын үед хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгатын дүн, “Хөх хөтөл” багт хийгдсэн гүйцэтгэлийн шалгалтын дүн, “Хуулиа мөрдье-21” сарын аяны хүрээнд хийгдсэн хяналт шалгалтын дүнг хэлэлцээд шийдвэр гаргаж цаашид анхаарах асуудлаар үүрэг чиглэл өгч ажиллалаа • Монгол улсын Ерөнхий сайдын 01 албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчдын сахилга бат, ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх, мэдлэг чадварыг сорих "АХА" тэмцээнийг аймгийн Саян телевизтэй хамтран зохион байгууллаа. • Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт нийт албан хаагчдын утасны жагсаалтыг хүргүүлж ажиллалаа. • Албан хаагчдын 2018 оны ээлжийн амралтын хуваарь гаргаж батлууллаа. 	
2	ЭМБХХХ	<p>Албан бичиг – 6 шийдвэрлэсэн – 1 шийдвэрлэх шатанд байгаа – 5 Өргөдөл – 1 шийдвэрлэх шатанд байгаа – 1 төлөвлөгөөт шалгалт – 12 төлөвлөгөөт бус шалгалт – 2 тандалт судалгаа гүйцэтгэлийн хяналт урьдчилан сэргийлэх – 2 зөвлөн туслах – 10</p> <p>ХАЛДВАР СУДЛАЛЫН ХЯНАЛТ</p> <ul style="list-style-type: none"> • МХГ-ын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Цагааннуур тосгоны ЭМТ, Ногооннуур сум дундын эмнэлгэд төлөвлөгөөт шалгалт, Чихтэй багын эмнэлгэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ • Цагааннуур тосгоны ЕБС, Ногооннуур сумын, ЕБС, Ногооннуур 	Цагаан сарын урьдчилан сэргийлэх хяналт хийх

сумын Ховд бага сургууль, Чихтэй бага сургууль төлөвлөгөөт шалгалт , Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэг Ногооннуур сумын хүүхдийн цэцэрлэг Зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ

- Өлгий сумын Ховд их сургуулийн цайны газарт төлөвлөгөөт бус шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, улсын Ерөнхий байцаагч Баян-Өлгий аймагт ажиллах үеэр өгсөн үүрэг даалгаврын дагуу аймгийн Засаг даргын А/63 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн Өлгий сумын 1 дүгээр багийн айл өрхөөр явж угаарын хийн хордлогоос сэргийлэх сэрэмжлүүлэг, сурталчилгаа явуулж, орсон айл өрх болгоны зуухны аюулгүй байдалд үзлэг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ард иргэд сонор сэрэмжтэй байх чиглэлээр “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлье”, сэдэвт сэрэмжлүүлэг хуудас тарааж зөвлөгөө өгч ажиллаж байна.

ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

- Аймгийн төвийн 13 багийн айл өрхүүдэд “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх” тандалт судалгаа, урьдчилан сэргийлэх сурталчилгаа явуулав Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, улсын Ерөнхий байцаагч Баян-Өлгий аймагт ажиллах үеэр өгсөн үүрэг даалгаврын дагуу Монгол Улсын шадар сайдын 2017 оны А/08 “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах” журмыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын А/63 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдлаа. Ажлын хэсэгт Багын засаг дарга, холбогдох байцаагч, мэргэжилтнүүдийг оролцуулан 13 багт ажиллах төлөвлөгөө гаргаж 2018 оны 2 сарын 18-аас 2 сарын 28-ны хүртэл багуудын оршин суугчид буюу айлуудын судалгааг үндэслэн “Угаарын хийн хордлого үүсгэх шалтгаан нөхцөл, илрэх шинж тэмдэг, түүнээс урьдчилан сэргийлэх “Зуухны аюулгүй байдал” “Угаарын хийн хордлогод өртөхгүй байх арга зам “-ын тухай нийт 1732 айл өрхөд 2100 ширхэг сэрэмжлүүлэг тарааж, мэдээлэл сурталчилгаа хийв. Тандалт судалгаагаар: Айл өрхүүдийн ахуйн хэрэглээний зуух нь стандартын шаардлага хангаагүй материалаар хийгдсэн, нүүрсний чанар муу, яндангийн өндрийн хийц нь “Ахуйн хэрэглээний зуух MNS 5216 : 2016 стандарт”-ийн шаардлагыг

хангаагүй, ард иргэдийн Угаарын хийн хордлогын талаар мэдлэг дутмаг зэрэг эрсдэлийг тогтоож илэрсэн зөрчлийг арилгуулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ХЯНАЛТ

- Буянт сумын Урантэмүүл, Алтай сумын Хасхажол, Альфия, Ветчихэртэй мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт, Цалгар, Мендуана, Сайгүлик мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн Цалгар, Мендуана мал эмнэлгийн нэгжүүд бага эрсдэлтэй, хяналт шалгалтанд хамрагдсан Хасхажол, Урантэмүүл, Альфия, Ветчихэртэй мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд дунд эрсдэлтэй үнэлэгдсэн.
- Алтай сумын 3-р багийн иргэн Х.Аскерийн өргөдөлийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Хохирогч, холбогдогч, гэрч нийт 4 хүнээс мэдүүлэг, 10 толгой малаас цусны дээж авч Мал эмнэлэг, ариун цэврийн лабораториор бруцеллёз өвчний вакцинжуулалтын дархлааны идэвхи тодорхойлуулахаар шинжилгээ хийлгүүлж байна.
- Манай аймагт үйл ажиллагаа явуулж буй арьс шир, ноолуурын үйлдвэрүүдийн сүүлийн 2 жилийн судалгааг хавсралт хүснэгтийн дагуу гаргаж, МХЕГ-ын ХАБХААХ-ын газарт цахимаар хүргүүлсэн

УРГАМАЛ ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ

- 3 аж ахуйн нэгжийн төмс, хүнсний ногооны лабораторийн шинжилгээний хариуг үндэслэн 3 заалттай 3 дүгнэлт үйлдэж ажилласан.
- Өлгий- Арго ХХК-ний тэжээл үйлдвэрлэж буй цехэд холбогдох байцаагчийн хамт очиж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

- МХЕГ болон аймгийн МХГ-ын 2018 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газрын даргын баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу Алтай, Буянт сумын соёлын төвд төлөвлөгөөт хяналт шалгалт, Ногооннуур сум, Цагааннуур тосгоны соёлын төвд зөвлөн туслах үйлчилгээг 2 дугаар сарын 22-ны өдрөөс 28-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэв. Төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд 6.7 Түүх, соёлын

		<p>үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг шалгах хяналтын хуудасыг ашиглаж, ТСҮХДЗ-ийн бүртгэл, хадгалалт хамгаалалтын эрсдэлийн үнэлгээг тогтоов. Хяналтын хуудасны үнэлгээгээр Алтай, Ногооннуур сум, Цагааннуур тосгоны соёлын төв “Дунд” эрсдэлтэй үнэлэгдэв. Мөн номын сан , орон нутаг судлах кабинетүүдийн үйл ажиллагааг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, бүтээлч санаачилгаатай ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, байгууллагын сургалт явуулан хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний явц байдлын талаар сумын удирдлагуудад танилцуулж санал бодлоо солилцов. Мөн зөрчлийг арилгуулах чиглэлээр улсын байцаагчийн албан шаардлага, зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>ХҮНСНИЙ ЧАНАР СТАНДАРТ ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ</p> <ul style="list-style-type: none"> • 2018 оны төлөвлөгөөний дагуу Алтай, Буянт сумдад үйл ажиллагаа явуулж байгаа “Асхар алтай”, “Каморо” хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар, “Бөртөш”, “Мөнх цаст алтай”, “Кызыл сай” нарийн боовны үйлдвэрлэл, аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг “Алтан сунхар”, “Күлдирген” нарийн боовны цехүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж эрсдэлийг үнэлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчлийн дагуу 7 албан шаардлага үйлдэж ажилласан. • “Хуулиа мөрдье-21”сарын аян, Цагаан сарын урьдчилан сэргийлэх шалгалтын танилцуулгыг хугацаанд нь МХЕГ-т хүргүүлж, МХГ-ын даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэр гаргуулж ажиллалаа. • Хүүхдийн эрүүл ахуй халдвар хамгааллын байцаагчтай хамтран “Цэцэрлэг болон сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны илчлэг, тэжээллэгийн хэмжээг тооцох аргачлал” сэдэвт онлайн сургалтанд суусан. 	
3	БОДБХХХ	<p>Албан бичиг – 9 шийдвэрлэсэн – 5 шийдвэрлэх шатаэд байгаа – 4 Өргөдөл – 4 хариутай – 2 төлөвлөгөөт шалгалт – 11 төлөвлөгөөт бус шалгалт – 5 тандалт судалгаа гүйцэтгэлийн хяналт урьдчилан сэргийлэх – 1 зөвлөн туслах – 6</p>	<p>2018 оны 2 сарын шалгалт, Зөвлөн Туслах Үйлчилгээ, бэлдэх удирдамж боловсруулах, батлуулах хийж дуугах.</p>

БОДБХХЯНАЛТ

- Газрын даргын үүрэг даалгаврын хүрээнд эрх олгогдсон улсын байцаагчдын ажлыг үнэлэх, дүгнэх журам, хавсралт боловсролуулж танилцуулсан.

АВТО ТЭЭВРИЙН ХЯНАЛТ:

- МХГ-ын даргын баталсан удирдамжаар тээвэр, байгаль орчны, хөдөлмөрийн чиглэлээр 2-р сард хамтарсан төлөвлөгөөт хяналт шалгалт хийх объектуудад урьдчилан мэдэгдэж, холбогдох байцаагч нарын хамт “Даян”, “ViP Car Wahn” авто засвар, угаалгын газруудад хяналт шалгалт хийж, шинэчлэгдсэн хяналтын хуудсаар эрсдэлийг тооцож, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар улсын байцаагчийн албан шаардлага, зөвлөмж өгөхөөр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Хяналт шалгалтын материалыг одоогоор цахим системд оруулах боломжгүй байна.
- Алтай, Буянт сумдад МХГ-ын даргын баталсан удирдамжаар төлөвлөгөөт хяналт шалгалтаар “Толганай” авто засварын газруудад шинэчлэгдсэн хяналтын хуудсаар эрсдэлийг тооцоход 42,2% буюу “Дунд” эрсдэлтэй үнэлэгдсэн ба илэрсэн зөрчлийг арилгуулхаар улсын байцаагчийн албан шаардлага үйлдэв

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ:

- Алтай, Буянт сумдад МХГ-ын даргын баталсан удирдамжаар төлөвлөгөөт хяналт шалгалтаар Буянт сумын Соёлын төвийн барилгад барилгын ашиглалтын чиглэлээр шинэчлэгдсэн хяналтын хуудсаар эрсдэлийг тооцход 61% буюу “ИХ” эрсдэлтэй үнэлэгдсэн ба Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийн ашиглалтын чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЯНАЛТ

- ХХК-ийн эзэн иргэн Х-аас 2018 оны 01 сарын 25 -ны өдөр гаргасан Баяннуур сумд төвлөрсөн халаалтын зуух барьсан “Киели жүйрик” ХХК нь барилга угсралтын ажлыг эрх бүхий байгууллагаас зогсоосон байхад үргэлжлүүлэн барьж сумын Захиргааны барилга, Соёлын төвд халаалт өгч “Дулаан үйлдвэрлэх, Дулаан түгээх, зохицуулалттай хангах, угсрах, барих зөвшөөрөл авахгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн гэсэн гомдолд зөрчлийн 1813000062 дугаартай хэрэг нээж Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8 дүгээр зүйл, 3.2 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон шалгаж

байна.

АВТО ЗАМЫН ХЯНАЛТ:

- Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн Хяналтын Газрын даргын баталсан 2018 оны 04/71, 04/72 тоот удирдамжууд, 04-07-036/01 тоот зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн дагуу Буянт сумын Сагсайн голын төмөр бетон гүүр, Алтай сумын Сагсайн голын эхийн Хар үзүүрийн, Бардамын голын, Цалгарын Ёлтын голын Бөртекийн модон гүүрүүдийн ашиглалт, хамгаалалт, засвар арчлалтын ажилд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, мөн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан болно.

ХЭМЖИЛЗҮЙН ХЯНАЛТ:

- Ногооннуур болон цагааннуур тосгонд төлөвлөгөөт, зөвлөн туслах үйлчилгээ хяналт шалгалт хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Холбогдох мэдээ мэдээлэлийг дараа 7 хоногт танилцуулах болно.

БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТ:

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2018 оны 01/66 тоот “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамж, Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 2018 оны 04/68, 04/53 тоот төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжууд, 04-04-029/01 тоот төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн дагуу Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч тухайн сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч нартай хамтран Буянт сумд үйл ажиллагаа явуулдаг Бөртөөш хоршооны, иргэн А.Болатханы Сайнхүлэг шатахуун түгээх станцуудад, Алтай сумын Засаг дарга, Газрын даамлуудын болон сумын төвд төвлөрсөн халаалтын зуухны үйл ажиллагаа явуулдаг Нуртөре ХХК-иудад 2018 оны 02 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд хяналт шалгалт хийж, мөн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллав.
- Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж аймгийн Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Өлгий сумын 9-р багийн Засаг дарга нартай хамтран айл өрхүүдэд Нүүрсний угаарын хийнээс хордохоос урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлаар ажиллав.
- 2 Бусад холбогдох байцаагч нар Ногооннуур болон цагааннуур тосгонд төлөвлөгөөт, зөвлөн туслах үйлчилгээ хяналт шалгалт хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Холбогдох мэдээ мэдээлэлийг дараа 7 хоногт танилцуулах болно.

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

- 2018 оны 2 дугаар сард хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын 2, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр хоёрыг хийж гүйцэтгэсэн . Ногооннуур сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг 1 объектийн төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ хийгдээгүй болно.
- Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 1 объектэд хийсэн.
- Аймгийн Асрамжийн газарт “зөрчил арилгуулах тухай” 9 заалт бүхий 04-06-031/22 тоот албан шаардлага, нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлтийг нөхөн төлүүлэх тухай 04-6-031/02 тоот 263707 төгрөгийн акт 1 үйлдэж, хүргүүлсэн.
- МХЕГ-ын даргын баталсан 01/70 тоот урьдчилан сэргийлэх хяналт хийх удирдамжийн дагуу Баян-нуур сумын нийгмийн даатгалын сан, тэтгэвэр тэтгэмжийн санд шалгалт хийж, 3 төрлийн судалгаа гаргаж, нийгмийн даатгалын байцаагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
- МХЕГ-аас зохион байгуулсан хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн өдрийг угтаж “ Нийгмийн сайн сайхны төлөө-хөдөлмөрийн хяналт” уриан дор бүтээлч ажил зохион байгуулах онлайн сургалтанд оролцсон.
- Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн удирдлага болон нийгмийн даатгалын байцаагчид МХЕГ-ын даргын баталсан 01/70 тоот урьдчилан сэргийлэх хяналт хийх удирдамжийн танилцуулсан.

ХӨДӨЛМӨР, ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТ

- Буянт сумын хүүхдийн цэцэрлэг, Алтай сумын төвлөрсөн халаалтын үйл ажиллагаа явуулдаг “Нуртөре” ХХК-ийн Ногооннуур сумын Улаанчулуут, Ховд, Чихтэй багийн бага сургуулиудад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж 14 заалт бүхий нэг албан шаардлага хүргүүллээ.
- “Даян” авто сервис, Алтай сумын Эрүүл мэндийн төвд төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч 13 заалт бүхий 2 зөвлөмжийг хүргүүллээ
- Аймгийн Цагдаагийн газрын дарга томилолтоор Улаанбаатар хотруу удирдах ажилтны зөвлөгөөнд оролцож буцах замдаа Толбо сумын Хашаат гэх газар авто тээврийн осолд орж гэмтсэн ослыг судлан үйлдвэрлэлийн ослын актыг баталгаажуулж, шуурхай мэдээг МХЕГ-ын medee.shuurkhai@yahoo.com цахим хаягаар хүргүүллээ.
- ЦШСГ-ын хүсэлтийн дагуу нийт ажилтануудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 9 сэдвийн хүрээнд сургалт явуулан, шалгалт авч баталгаажууллаа.

4	ЭИХХЦХХ	<p>Албан бичиг шийдвэрлэсэн шийдвэрлэх шатаэд байгаа Өргөдөл – 3 шийдвэрлэсэн – 3 төлөвлөгөөт шалгалт – 4 төлөвлөгөөт бус шалгалт тандалт судалгаа гүйцэтгэлийн хяналт – 4 урьдчилан сэргийлэх зөвлөн туслах</p> <p>ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ</p> <ul style="list-style-type: none"> • Нийт давхардсан тоогоор 13 аж ахуйн нэгжийн 1508.6 тн бараа, бүтээгдэхүүнийг хяналтанд хамруулж 31 мэдэгдэл, 12 импортын гэрчилгээ олгож ажилласан. • Улсын хилээр: • <u>Орох хөдөлгөөний чиглэлд:</u> 196 тээврийн хэрэгсэл, 597 зорчигч • <u>Гарах хөдөлгөөний чиглэлд:</u> 196 тээврийн хэрэгсэл, 609 зорчигч зорчисон байна. • Улсын хилээр орсон тээврийн хэрэгслүүдэд 403.000 төгрөгийн ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан байна. <p>УХЦХяналтаар:</p> <ul style="list-style-type: none"> • 1 ААНэгжийн 20.4 тн жимс, хүнсний ногоо • 4 ААНэгжийн 500 тн малын тэжээл импортоор орсон ба эдгээрт 9.2.2, 9.2.3 кодтой хяналтын хуудсаар бичиг баримт, биет үзлэг шалгалт, лабораторийн шинжилгээт хяналт шалгалтыг хийж 15 импортын гэрчилгээ олгож ажилласан. • 1 ААНэгжийн импортлож буй хүнсний улаанбуудайнаас дээж авч 2 үзүүлэлтээр лабораторийн шинжилгээнд хамруулсан. Гарсан шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн 1 дүгнэлт үйлдсэн. <p>МЭ-ийн хяналтаар:</p> <ul style="list-style-type: none"> • 2 ААНэгжийн 39 тн хонины ноос импортоор орж 9.1.2 хяналтын хуудсаар хяналтыг хийж импортын гэрчилгээ 2-г олгон ажилласан. <p>ЭАХХХ-ын хяналтаар:</p> <ul style="list-style-type: none"> • 3 ААНэгжийн импортоор оруулж ирж буй 67.9 тн хүнсэнд 9.3.1 хяналтын хуудсаар бичиг баримт, биет үзлэг шалгалт хийж 3 мэдэгдэл олгон улсын хилээр нэвтрүүлэв. <p>ХСЧХяналтаар:</p> <ul style="list-style-type: none"> • 2 ААНэгжийн 445 тн дизель түлш, 3 ААНэгжийн 122.8 тн бензинд 9.4.3 хяналтын хуудсаар хяналтыг хийж нийт 12 мэдэгдэл олгосон. 	
---	---------	---	--

		<ul style="list-style-type: none"> • 1 ААНэгжийн 3.5 тн хүнсэнд хяналт хийж 1 мэдэгдэл үйлдэн ажилласан. <p>ГҮНД ХИЙГДСЭН АЖИЛ</p> <ul style="list-style-type: none"> ▶ Цагааннуур боомтын 7 хоногийн цахим мэдээг тухай бүрд ЭИХХЦХГазарт илгээж ажиллаж байна. ▶ 3 ААНэгжийн ирүүлсэн ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн импортлох хүсэлтийн дагуу 3 импортын мэдэгдэл олгосон. ▶ 1 ААНэгжийн ирүүлсэн мал, амьтны гаралтай түүхий эд болох хонины ноос импортлох хүсэлтийн дагуу 1 импортын мэдэгдэл олгов. 	
5	Нэгдсэн лаборатори	<p>7 ХОНОГТ ЛАБОРАТОРИ ТУС БҮРТ ХИЙГДСЭН ШИНЖИЛГЭЭ</p> <ul style="list-style-type: none"> • Химийн хор судлал лаборатори лабораторид ирсэн 30 хүнсний дээж, 3 ундны усыг 62 үзүүлэлтээр шинжилгээ хийгдэж байна. • Нян судлал лабораторид 19 арчдасыг 10 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн • Цагааннуур боомтын химийн лаборатори 3 дээжийг 12 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна • Нийт 14 ААНИ-ээс ирсэн 55 дээжийг 208 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна <p>Хүсэлтээр</p> <ul style="list-style-type: none"> • Улаанхус сумын Еламан дэлгүүрээс 3 дээж • Зергер интернешнл ХХК-с 10 арчдас • Улаанхус сумын Ойгор багийн дунд сургуулиас 1 усны дээж <p>ЭАХХХУБ Б.Гүлбану</p> <ul style="list-style-type: none"> • Дэлүүн сум Таван салаа сургуулиас 5 хүнс 1 ундны ус • Алтай сумын хүүхдийн цэцэрлэгээс 17 дээж • Улаанхус сумын ЕБС-иас 9 хүнс, 1 ус дээж <p>УХХЦХУБ Д.РОЗА</p> <ul style="list-style-type: none"> • Баяннуур сум иргэн Маруа, Дамыс, Салдатбек, Даян, Бахытжан нараас 5 үрийн төмсний дээж <p>УХХЦХУБ Д.Алима</p> <ul style="list-style-type: none"> • Галин интернешнл ХХК-с 1 дээж • Хийморилонг эрчүүдийн хүч ХХК-с 1 дээж • Жасулан ХХК-с 1 дээж <p>Өнгөрсөн хугацаанд 55 сорьцыг шинжилгээнд хамруулсан. Нийт 55 сорьцын:</p>	

	<ul style="list-style-type: none"> • Төлөвлөгөөт бус хяналтаар • Урьдчилан сэргийлэх хяналтаар 39 сорьц • Хилийн хяналтаар 3 сорьц • Хүсэлтээр 13 дээж <p>Өнгөрсөн 14 хоногт хийсэн шинжилгээнээс Зергер интернешнл ХХК-ы мах нядлах цэхээс авсан 10 арчдасны 3 нь бохирдолтай гарсан.</p>	
--	--	--

АЙМГИЙН УАШЗ-ӨӨС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан
1	Иргэдээс ирүүлсэн гомдлыг барагдуулах ажлын хүрээнд Мэргэжлийн хяналтын газрын байцаагчдыг оролцуулан өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж, “Зайд” БДС-д явагдсан олимпиадад оролцсон сурагчдын материалыг хянаж, холбогдох хүмүүсийг байлцуулан дараагийн долоо хоногт ажлын хэсгийн дүнг танилцуулах, иргэдээс гаргасан шүүмжлэлд дүгнэлт хийх	7 хоног	Энэхүү асуудалтай манайд хамааралгүй болно. Энэ асуудлын талаар БСУГ-т хандана уу
2	Аймгийн хэмжээнд ард иргэд угаартах явдал их гарч байгаа тул холбогдох мэргэжлийн болон хяналтын байгууллагууд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлагуудтай хамтарч ажиллан хүүхдүүд, эцэг эхчүүдэд сэрэмжлүүлэг хийж, сумдад мэдээллийг хүргэж ажиллах	7 хоног	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, улсын Ерөнхий байцаагч Баян-Өлгий аймагт ажиллах үеэр өгсөн үүрэг даалгаврын дагуу аймгийн Засаг даргын А/63 тоот захирамжаар байгуулагдсан Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Өлгий сумын Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн Өлгий сумын 13 багт угаарын хийн хордлогоос сэргийлэх сэрэмжлүүлэг, сурталчилгаа явуулж, орсон айл өрх болгоны зуухны аюулгүй байдалд үзлэг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ард иргэд сонор сэрэмжтэй байх чиглэлээр “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлье”, “Ундны усны аюулгүй байдал” сэдэвт сэрэмжлүүлэг хуудас тарааж зөвлөгөө өгч ажиллаж байна.
3	Ард иргэдээс гаргасан өргөдөл , гомдлыг цаг тухайд нь сонсож шийдвэрлэх зорилгоор байгууллага бүр энэ долоо хоногоос эхэлж тусгай утас ажиллуулах, утасны дугаарыг орон нутгийн радио телевизээр зарлах, ТЗУХ-ийн дарга утасны дугааруудыг шуурхай хурал дээр мэдээлэх	7 хоног	Тусгай утас гаргах төлөвлөгөөг гөргөж хэрэгжүүлж байгаа. ТЗУХ-ийн даргад холбогдох утасны дугаар 99998997 /М.Галымбек/

4	Сар шинийн баяртай холбоотой байгууллага бүр ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлж, харуул хамгаалалтаа чангатган ажиллах	7 хоног	Газрын даргын А/02 тушаалын дагуу ажлын хэсэг байгуулж баярын өдрүүдэд байгууллага дээр хувиарын дагуу ажилласан болно. Ямар нэгэн асуудал гараагүй.
---	---	---------	--

Мэдээг нэгтгэсэн

Хэвлэл мэдээллийн ажилтан: Х.Жанар